

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 4-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

1. БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ СЕМИНАРТ ХАМРАГДСАН БАЙДАЛ

1.1 Хөгжмийн багш Б.Буяндэлгэр 2019.4.22-26-ны хооронд Улаанбаатар хотод БМДИ-ээс зохион байгуулсан 1дэхь жилдээ ажиллаж байгаа багш нарын үндсэн сургалтанд хамрагдсан. Номын санч, бичиг хэргийн ажилтан А.Дэлгэрнасан БСУГ-ын бичиг хэргийн ажилтнуудын нэгдсэн сургалтад хамрагдсан.

2. “УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

2.1 Багш нарын ээлжит хичээлийн хөтөлбөрийн чанарт анхаарал тавин заавал ээлжит хичээлийн төлөвлөлтэй хичээл оруулах тал дээр анхааран ажиллаж байна.

2.2 Сургалтын менежер М.Нарангэрэл Багш Н.Бямбодолгор Б.Ичинхорлоо, Б.Мягмарсүрэн Л.Эрдэнэчимэг нарын хичээлд тус бүр 3 удаа сууж сурагчдыг багаар ажиллуулах бие дааж хийх бүтээлч даалгавар өгөх хичээлийн хэрэглэгдэхүүнийг хангалттай бэлтгэх талаар зөвөлгөө өгөн ажиллалаа.

2.34 сарын 15-с 4сарын 25- ны хооронд Илэрхийллийн болон өгүүлбэртэй бодлогын 7 хоногуудыг зохион байгуулж багш бүр ангидаа тухайн сэдвээр давтлага өгч давтлагын мөрөөр шалгалт авч үр дүн, ахицыг тооцон ажиллаж байна.

2.4 “Бид цэвэр бичигтэн” уралдааны зохион байгуулан 1-р ангийн сурагчдын эрдмийн баяраар үзэсгэлэн гаргахаар бэлтэл ажил хийгдээд байна.

2.5 1-5-р ангийн сурагчдын дунд “Нэг хүүхэд- Нэг витамин” сайн үйлсийн аян зарлан явууллаа. Цугларсан витаминаар 2 өндөр настан, 2 хүүхэд, СӨББ-ын 1 бүлгийн хүүхдүүдэд витамин өгч дархлааг нь дэмжлээ.

2.63, 4-р ангийн анги дэвших шалгалтын блюпринтийн дагуу 3-р анги нэгдмэл агуулгаар- 1, 4-р анги нэгдмэл агуулга болон математик, монгол хэл, байгалийн ухааны нийт 7 хичээлээр анги дэвших шалгалтын даалгавар боловсрууллаа.

2.7 Бага ангийн 4 залуу багшаас хуулийн болон цээж бичгийн шалгалт авч үр дүнг багш бүрт танилцууллаа.

2.8 Багш нар 4-р улирлын хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулсан.

2.9 Судлагдахуун бүрээр 4-р улирлын даалгаврын сан боловсруулж, файлаар өгч байна.

2.10 Хичээлийн цагаар гар утас хэрэглэхгүй байх тал дээр багш, сурагчдыг хэвшүүлж, хяналт тавьж ажилласан.

2.11 БСУГ-аас мэргэжлийн багш нарт явуулсан блюпринтийн загварын дагуу

Судлагдахуун бүрээр блюпринт боловсруулж, 5.3-ны дотор БСУГ-т явуулна.

2.12 6-р ангийн Монгол-хэл, Англи-хэл, 7-р ангийн Математик, 10-р ангийн Түүхийн хичээлүүдээр 2019 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр сургуулийн захирлын тушаалаар томилогдсон шалгалтын комиссууд зохих журмын дагуу олимпиадыг авч, матрицыг нэгтгэн заасан хугацаанд нь явуулсан.4

2.13 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр БСУГ-аас “Байгалийн Ухаан”-ны хичээлүүдээс ЭЭШ-ын урьдчилсан шалгалтуудыг зааврын дагуу авч, сурагчдын хариултын хуудсыг нэгтгэн явуулсан.

2.14 2019.4.23-ны өдөр 9-р ангийн эцэг, эх, сурагчидтай хичээл ордог багш нартай хамтран ангийн хурал зохион байгуулсан.

2.15 2019.4.23-ны өдөр 6-10-р ангийн Сурагчдын дунд БСУГ-аас “Математик-Цаг”-сонины нэрэмжит олимпиадыг зохион байгууллаа.

3. СУРГАЛТЫН ОРЧИН САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

3.1 Багш, хөгжлийн өрөөнд 35000 төгрөгний үнэтэй самбар “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”-иар хийж байрлуулсан.

3.2 БУЗАН, НУЗАН-ийн багш нар судлагдахуун бүрээр мэдээллийн самбар хийж 2-р давхарын коридорт байршуулсан.

3.3 Сургалтын менежер, нийгмийн ажилтны ажил үүргийн хуваарийн самбар гаргасан.

4. ХҮҮХДИЙН АВЪЯАС, СУРЛАГА ХҮМҮҮЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.6 СЭЭЗ-тэй хамтран эцэг эхчүүдийн дунд “ Та 5-р ангийн хүүхдээс ухаантай юу” танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулж нийт 7 баг оролцож 4а,2а,10а- ангийн эцэг эхийн багууд амжилттай оролцож Өргөмжлөл,мөнгөн шагналаар шагнагдлаа

4.7 Ахлах ангийн сурагчдаас фейсбүүк хэрэглээний талаарх судалгаанд нийт 19 сурагч хамрагдаж цахим хэрэглээг удаан хугацаагаар хэрэглэх нь хүний эрүүл мэнд нүдний хараанд хэрхэн сөргөөр нөлөөлдөг тухай хэлэлцүүлэг хийсэн.

4.8 Дотуур байрын ажилчдаас “Хүүхэд хамгаалал танай гэрт” дэвжээ тэмцээнийг багш ажилчдын дунд зохион байгуулахад 5 баг авьяас чадвараара өрсөлдөж 2-р байр эзэлсэн.

4.9 2018-2019 оны хичээлийн жилийн сургуулийн “ Гар бөмбөгийн аварга “шалгаруулах тэмцээнд нийт 13 багийн 90 гаруй сурагчид хурд хүч авхаалж самбаагаараа өрсөлдөн 12а ангийн сурагч Нэргүй ахлагчтай баг Алтан медаль мөнгөн шагнал, Жамбалсүрэн ахлагчтай баг мөнгөн медаль 7а-ангийн сурагч А. Алтансоёмбо ахлагчтай баг хүрэл медал мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа.

4.10 Номын сан: Зохиолч Ц.Гайтавын мэндэлсний 90 жилийн ойд зориулан

шүлгийн уралдааныг насанд хүрэгчид, сурагчдын дунд зохион байгуулж, МХУЗ-ын багш Ц.Үйзэнхорлоо, 10а ангийн сурагч Б.Удвал нар Аймгийн уралдаанд оролцлоо.

5 СУРГАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР:

5.1 Сургуулийн ажилчдад “ Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сургалтыг явуулж 12 ажилчид оролцож хүүхдийн орчинд ажиллаж буй ажилчдын арга барилыг эерэг болгох сургалтыг зохион байгуулан явуулсан

5.24а- ангийн сурагчидтай найзынхаа сайн сайхан зан чанарыг дэмжиж туслах, өөрийнхөө дутагдлыг хэрхэн яаж засах вэ? Талаар ярилцлага хэлэлцүүлгийг хийсэн

5.3 Захирал Ц.Хоролмаа нийт багш ажилчдад “ Төрийн албан хаагчийн ёс зүйн” дүрэм журмуудын талаар сургалт явуулсан

5.4 Хүмүүжил, төлөвшлийн талаар дотуур байрын сурагчдад “ Өөдрөг үзэл” сургамжит өгүүллэгээр хэлэлцүүлэг зохион байгуулсан нь хүүхдүүдийг өөдрөг үзэлтэй байхын ач холбогдлын талаар харилцан ярилцсан үр дүнтэй сургалт боллоо.

5.5 Эрсдэлд орж болзошгүй нэр бүхий 2 сурагчтай ганцаарчилсан уулзалт, зөвлөгөө хийж тэмдэглэл хөтлөв

5.6 Хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажиллах төлөвлөгөөний дагуу 04-р сарын 17 ны өдөр зохион байгуулсан“ Ажил мэргэжил сурталчлах өдөрлөгөөр дотуур байрын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулсан

5.7 Сумын ХХХ-багтай Туяа баг дээр очиж ажиллах үеэр сургуулийн дотуур байрын үйл ажиллагааны талаар үзүүлэн самбараар иргэдэд сурталчлан, гарын авлага боршур тарааж мэдээлэл хийсэн

6 ОЛИМПИАД, УРАЛДААН ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН БАЙДАЛ

6.1 Аймгийн төрөлжсөн олимпиадад 55 төрлөөр оролцож химийн хичээлээр 12а ангийн сурагч Э.Мичидмаа мөнгөн медаль(Багш С.Оюун-Эрдэнэ), 10а ангийн сурагч Б.Удвал мөнгөн медаль(П.Бундхорлоо), монгол хэл, бичгийн хичээлээр 12а ангийн сурагч Э.Мичидмаа, А.Луу-Эрхбаяр нар 4,5-р байр(Э.Даваа), нар тус тус амжилттай оролцлоо.

Мөн “Математик цаг сонин”-ны нэрэмжит олимпиадын 2-ын давааг сургууль дээрээ амжилттай зохион байгууллаа Үүнд бага ангийн 4 багш, 1-5-р ангийн 22 сурагч хамрагдлаа.

7 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ

- 7.1 Багш сурагчдын эрүүл мэндэд хяналт тавин, эрүүл мэндийн тусламж үзүүлэх шаардлагатай багш, ажилчид, сурагчдад анхны тусламж эмийн болон эмийн бус эмчилгээ хийсэн. Үйлчлүүлсэн багш ажилчид нийт 10 эмийн эмчилгээ-6 эмийн бус эмчилгээ-4 Үйлчлүүлсэн сурагч 3 эмийн эмчилгээ-3 эрүүл мэндийн тусламж үзүүлэн заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.
- 7.2 Харааны өөрчлөлттэй гарсан 12 сурагчдыг нүдний эмч н.Бямбасүрэнд үзүүлж 8 сурагч, 4 иргэнийг шилтэй болгосон.
- 7.3 Алжаал тайлах бариа засалд 4 багш ажилчид хамрагдсан.
- 7.4 Дотуур байрны сурагчдын хоолны орц норм, илчлэг чанар, хадгалалт зэрэгт хяналт тавин 14 хоногт 1 удаа амталгаа хийж заавар зөвлөгөө өгч 2 тогоочтой хамтран сурагчдыг хуваарийн дагуу гал тогоонд цэвэрлэгээ үйлчилгээнд туслуулан ажиллаж байна
- 7.5 СӨББ-ийн 4 бүлгийн нийт 65 хүүхдүүдэд өсөлт хөгжил, шүд, чих хамар хоолойн үзлэг хийсэн
Өсөлт хөгжил хэвийн-51
-1 эрсдэлтэй-8
Илүүдэл жинтэй-6
- 7.6 Шүдний цооролттой-20 Хоолой өвдсөн-6 хүүхэд үзэж зөвөлгөө өгч жингийн эрсдэлтэй хүүхдүүдийг нэмэгдэл хооллолд хамруулах, витаминжуулах шүдний цооролттой 8 хүүхдийг эмчлүүлэх талаар ангийн багш нарт нь үүрэг даалгавар өгч хоолой өвдсөн 6 хүүхдэд эмийн эмчилгээ бичиж хоолой, ам зайлуулах талаар зөвлөв.
- 7.7 Өвөрхангай аймгийн Тарагт суманд Улсын аваргын Чөлөөт бөхийн тэмцээний бэлтгэл хийж байгаа 27н сурагчдын амин үзүүлэлт даралт, халуун, шүд, чих хамар хоолой, зүрх судас, амьсгал зэргийг үзэхэд Эрүүл-14 Шүдний цооролттой-9 Орви ханиадтай-3 Цистит-1 хүүхдүүдэд эмийн эмчилгээ бичиж, шээсний шинжилгээ өгөх талаар зөвөлгөө өгч дасгалжуулагч багш нарт нь эмчлүүлэх өдөрт 2 удаа содтой, давстай усаар хоолой, ам зайлуулах талаар зөвөлгөө өгч ЭМТ-н нийгэм эрүүл мэндийн ажилтан Г.Ууганзаяатай хамтран “Амны хөндий, Шүд , гар угаах” гэх мэт сэдвүүдээр товч мэдээлэл зөвөлгөө өгч ажилласан.
- 7.8 Сургууль, дотуур байрны цэвэрлэгээнд хяналт тавин заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

7.94.2нд “ХАБ” 4.1-4.2 хооронд Дархан-Уул аймгийн “Багш, шавь нарын уулзалтанд” сууж кредит цаг бүрдүүлсэн.

7.10 Сургууль, дотуур байрын гадна орчинд их цэвэрлэгээ хийсэн.

7.11 МСҮТ-н ХАБ-н ахлах ажилтан Н.Эрдэнэсүвд, Б.Нямдаваа, зөвлөлийн дарга М.Төрболд нар сургалт “Аха” тэмцээн зохион байгуулсан Нийт 40 төрийн албан хаагч нар оролцож, “Аха” танин мэдэхүйд Э.Даваасүрэн 1-р байр Ш.Батбилэг 2-р байр У.Цэрэнлхагва 3-р байр тус тус эзэлсэн.

7.12 Дотуур байрын сурагчдын эрүүл ахуйд хяналт тавин, 7 хоногт 2 удаа дотуур байрын сурагчдын ариун цэвэр шалгаж заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

7.13 Дотуур байрын сурагчдад “Гарын эрүүл ахуй” “Шүд угаах дараалал” сэдвээр сургалт зохион байгуулсан нийт 29 сурагчид оролцсон.

7.14 Өглөө бүр дасгал хийж хэвшүүлж байна.

7.15 Мэргэжил сурталчилах өдрөөр төрийн албан хаагч, ард иргэд нарын нийт 18 хүний даралт үзэж зөвлөгөө өгч ажилласан.

7.16 ЕБС-с зохион байгуулсан “Хөгжөөнт буухиа” тэмцээнд амжилттай оролцож 3-р байр эзэлсэн.

7.17 Дотуур байранд жижүүр Х.Бавуусүрэнтэй хамтарч “Эко” орчин бүрдүүлсэн 1-рт сурагчдын хувцасны тавиур 2-рт угаалгийн толь тогтоосон.

7.18 Сургуулийн багш ажилчдын дунд “Эрүүл мэнд идэвхтэй хөдөлгөөн /хөгжимтэй дасгал/ ыг орой 18 цагаас эхлэн 1 цагийн багтаамжтай сурагчдыг их завсарлагаагаар чөлөөт дасгал хөдөлгөөнийг бүжгийн гэрээт багштай хамтран хийж эхлээд байна Мөн ахлах ангийн 7сурагчдад үндэсний бүжиг зааж сургасан

7.19 Ахлах ангийн сурагчдаас фэйсбүүк хэрэглээний талаарх судалгааг авч нэгтгэн тэдний эрүүл мэнд нүдний хараанд хэрхэн сөргөөр нөлөөлдөг тухай хэлэлцүүлэг хийсэн.

7.20 Дотуур байрын сурагчдын зөвлөлийн ажиллах төлөвлөгөө гарган,сурагчдыг цаашид ажиллах чиглэл өгсөн

8 Сургуулийн орчинд хүүхдийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд анги танхим өрөө тасалгааны цахилгааны утас, монтажийг шалган авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган 2 тэмдэг тэмдэглэгээг авчирч байрлуулсан.

9 Багш ажилчдыг эрүүл мэндийн багц үзлэгт орох хуваарь гарган БОЭТ болон Ариун санаа, Чинмэнд эмнэлэгүүдэд үзлэг оношлогоо шинжилгээнд хамрагдсан

10 Дотуур байрын сурагчдын дунд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх , хамтач нөхөрсөг орчин бүрдүүлэн ажлын хүрээнд “Хөгжөөнт тэмцээн 4- удаа

хүмүүжил төлөвшлийн талаар сургалт 5 амьдрах ухааны сургалт 4 удаа явуулсан

11 Дотуур байрын сурагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авсан SCHOOLPOLICE эцэг эхийн эргүүлийг 3а ангид хуваарийн дагуу хяналт тавин ажиллууллаа.

Нэмэлт ажлууд

Бүтээлч ажлын хүрээнд

- Цагдаагийн газрын 80 жилийн ойн урлагийн тоглолтыг 36-багш ажилчид үзэж 360000 төгрөгийн орлого оруулж 1,000,000 төгрөгийн хандив өргөсөн.
- Сургуулийн орчинд болон дотуур байранд 20ш цэцгийн тавиур хийж ЭКО – орчин бүрдүүллээ.
- Дотуур байрын ажилчид 2 х1,8 ийн харьцаатай ширдэг ширж байрын сурагчдын хүүхэд хөгжлийн өрөөний ёс заншлын буланг шинээр тохижуулах ажлыг эхлүүлэн хийж байна.

Оролцоо

- 2019.4.3-ны өдөр Дотуур байрны багш, ажилчдаас зохион байгуулсан “Хүүхэд хамгаалал танай гэрт”-сэдэвт дэвжээнийг нийт багш ажилчдын дунд зохион байгуулж Дотуур байрын баг 1-р байр, Захиргаа аж ахуйн баг 2-р байр, БАЗАН 3-р байр эзэлсэн.
- 2019.4.4-ны өдөр Хөдөлмөрийн Аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан.
- 2019.4.4-ны өдөр Сумын нийгмийн даатгалын байцаагч Ш.Оюун, Иргэний бүртгэлийн байцаагч Д.Наранцэцэг, сургуулийн захирал Ц.Хоролмаа нарын хийсэн сургалтад хамрагдсан.